



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Иргэний зориг ногоон нам
(ИЗНН)-ын дүрмийн өөрчлөлтийг
улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Г.Банзрагч, Х.Батсүрэн, М.Батсуурь, Н.Баярмаа, Н.Батзориг, Н.Батчимэг, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-ын дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг Танхимын тэргүүн Г.Алтанчимэг илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-ыг төлөөлж тус намын дарга Б.Батбаатараас 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Улсын дээд шүүхэд өргөдөл гаргасан.

Уг өргөдөлд “Үндэсний Зөвлөлийн Хорооны 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн ээлжит хурлаар намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан тул Улс төрийн намын тухай хуулийн 15.3, намын дүрмийн 38.3-т заасны дагуу бүртгүүлэхээр хүргүүлж байна” гээд нийт 92 хуудас, 1 ширхэг флаш материал ирүүлжээ.

Дээрх өргөдөл, хавсралтаар ирүүлсэн баримтууд нь Улс төрийн намын тухай хууль болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын Хавсралт №5А-д заасан бүрдүүлбэрийн шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, журмын 6.6-д зааснаар Нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-ын дүрмийн өөрчлөлтийг дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэв.

Нэг.Намын дүрэмд өөрчлөлт оруулсан шийдвэр гаргах ажиллагааны талаар:

1.1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг

хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэжээ.

Тус намын /2024 оны/ дүрмийн 20 дугаар зүйлд “Намын төлөөллийн төв байгууллага буюу “Үндэсний хороо”, 22 дугаар зүйлд “Үндэсний Хорооны бүрэн эрх”, 22.1-д “Үндэсний Хорооны Хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:”, 22.1.1-д “Намын дүрэм, намын мөрийн хөтөлбөрт, нэмэлт, өөрчлөлт оруулах;” гэж тус тус заасан.

Гэтэл Улсын дээд шүүхэд бүртгэгдээгүй тус намын дүрэмд төлөөллийн төв байгууллагыг “Үндэсний Зөвлөлийн Хороо” гэж нэрийг өөрчилж, улмаар тус хороо 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хуралдаж, намын дүрмийн өөрчлөлтийг баталсан нь намын дүрмийн дээрх заалтад нийцэхгүй байна.

Нөгөө талаар, Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-ын 7 бүлэг, 38 зүйл, 322 заалттай дүрмийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоолоор бүртгэсэн.

Шинээр байгуулагдсан гэх Үндэсний Зөвлөлийн Хорооны 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хурлын “дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах тухай” ҮЗХ-01/08 дугаар тогтоолоор намын дүрмийн 1 бүлэг, 7 зүйл, 185 заалт (өөрчлөлт оруулсан-122, нэмсэн-64, хассан-7)-д өөрчлөлт оруулжээ. Уг өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтэрсэн байх тул төлөөллийн төв байгууллага намын дүрэмд өөрчлөлт оруулах эрхгүй, Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;” гэж зааснаар намын Их хурлын онцгой бүрэн эрх байна.

Хоёр.Намын дүрмийн өөрчлөлтийн талаар:

2.1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 27 дугаар зүйлийн 27.13-т “Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна” гэж заасан.

Хуулийн дээрх заалтыг үндэслэн Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 35 дугаар тогтоолын үндэслэх хэсгийн 3-т “... хуулийн 27.13-т заасан намын дүрмээр зайлшгүй зохицуулах асуудлыг орхигдуулсан ...” гэж дурдсан байна.

Өөрчлөлт оруулсан намын дүрмийг судалж үзэхэд, дүрмийн 3.3-т “Нам дэргэдээ эмэгтэй, ахмад, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангах, дэмжин ажиллах, нийгэм эдийн засгийн болон бусад салбарын бодлогын асуудлаар зөвлөлдөх, намын бодлого, үйл ажиллагаа нь хүний эрх болон жендэрийн эрх тэгш байдалд нийцэж байгаа эсэхийг үнэлэх зэрэг чиг үүрэгтэй бүтцийн нэгж байгуулж болно” гээд, 36.1-д “Намд олгох жил бүрийн төрийн санхүүжилтийг доор дурдсан хувиар бүтцийн нэгжид зарцуулна:”, 36.1.1-д “төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог

дэмжих, сургаж бэлтгэх;”, 36.1.2-т “төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах;”, 36.1.3-т “төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх” гэж бүтцийн нэгжид төрөөс үзүүлэх санхүүжилтийг хуваарилах талаар тусгаж, харин салбар нэгжид хуваарилах асуудлыг зохицуулаагүй, хэрэв төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг салбар нэгжид хуваарилах зохицуулалтыг хэрэглэхгүй гэж үзвэл намын дүрэмд тодорхой бичих нь зүйтэй.

2.2.Мөн намын дүрмийн 20.2-т “Үндэсний Зөвлөлийн Хороо 219 хүртэл гишүүнтэй байна”, 25.2-т “Улс Төрийн Зөвлөлийг Үндэсний Зөвлөлийн Хорооны гишүүдээс бүрдүүлэх ба 45 хүртэл гишүүнтэй байна ...” гэж тус тус заасан. Намын төлөөллийн төв, гүйцэтгэх төв байгууллагын бүрэлдэхүүний тоог дээр дурдсанаар тодорхой бус заах нь хуульд нийцэхгүй. Иймд намын дүрэмд төлөөллийн төв байгууллагын гишүүдийн тоог тодорхой тусгах зайлшгүй шаардлагатай.

2.3.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.6-д “Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтныг гүйцэтгэх төв байгууллага тус тус сонгоно” гэж заасан.

Гэтэл намын дүрмийн 19.1-д “Дараах асуудлыг Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу намын Их хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:”, 19.1.2-т “Намын даргыг сонгох, чөлөөлөх” гээд, 22.1-д “Үндэсний Зөвлөлийн Хорооны Хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:”, 22.1.5-д “Намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага 4 жилийн хугацаатай сонгож, батламжилна ...;”, 22.1.16-д “Намын дарга нас барсан, өөрийн хүсэлтээр өргөдлөө өгсөн, өөр ажилд шилжсэн тохиолдолд чөлөөлөх, Намын даргыг сонгон томилох” гэж тус тус заасан нь намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллагын чиг үүрэг давхардсан гэж үзэхээр байна.

Түүнчлэн намын дүрмийн “36.1.5” гэсний дараа “36.1.7” гэж дугаарласан алдааг залруулах шаардлагатай.

Иймд, дээрх үндэслэлээр Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-ын хүсэлтийг хангах боломжгүй. Өргөдөл гаргагч нь намын дүрэмд заасан журмын дагуу Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д заасан намын дүрэмд зайлшгүй тусгавал зохих асуудлуудыг тусгаж, энэ дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг оруулахдаа намын Их хурлаар хэлэлцэх, намын дүрмийн өөрчлөлтийг шинэчлэн батлахдаа дүрмийн заалт зөрчилгүй байх, хуульд заасан шаардлагыг хангаж, дахин хандах эрхтэй болно.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасныг баримтлан Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-ын дүрмийн өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Г.АЛТАНЧИМЭГ